



**ЗАВХАН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 13

Улиастай

Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх
таван жилийн үндсэн чиглэл батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.11.1, 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтуудыг үндэслэн Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг нэгдүгээр, Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хоёрдугаар, хөрөнгө оруулалтын ажлыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. “Завхан аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн аймаг, сумдын төсөвт тусган хэрэгжүүлж, биелэлтийг Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Д.Үнэнхүү/-д даалгасугай.

ДАРГА

Ц.УЛАМ-ОРГИХ



150200041



ЗАВХАН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

АЛСЫН ХАРАА:

Завхан аймаг нь эдийн засаг, хүний нөөцийг үр бүтээмжтэй ашиглан, иргэдийн ажиллаж, амьдрах таатай нөхцөлийг бүрдүүлж, тогтвортой ногоон хөгжлийг дэмжсэн аймаг байна.

АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ТУЛГУУР ЧИГЛЭЛ:

- Завхан аймгийн эдийн засгийн нөөцөд тулгуурласан хөгжил
- Завхан аймгийн нийгмийн үйлчилгээ ба хүний хөгжил
- Ногоон хөгжилд суурилсан орон нутгийн хөгжил

НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ

Эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлнэ.

1.1. ӨВ СОЁЛ

1.1.1 Соёлын биет болон биет бус өвийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сан бий болгож, өвлөн уламжлагчдыг өсвөр үе, залуучуудад таниулж, уламжлуулна.

1.1.2 Номын сангийн цахим сан хөмрөгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

1.1.3 Үндэсний бахархал, Монгол өв соёлоо өвлүүлэхэд чиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно.

1.1.4 Монгол хэл, бичгийн хэрэглээг нийтийн болон албан хэргийн түвшинд нэмэгдүүлнэ.

1.1.5 “Үндэсний бахархал, монгол өв соёл” арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.1.6 Соёлын биет, биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.

1.1.7 Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмж, нэр төрөл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ

Нийгмийн суурь үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай хүргэж, эрдэм мэдлэгтэй, эрүүл чийрэг, нийгмийн идэвхтэй, хүнлэг, ёс суртахуунтай, гэр бүлдээ ээлтэй Монгол хүнийг төлөвшүүлнэ.

2.1. БОЛОВСРОЛ

- 2.1.1 Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.
- 2.1.2 Бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлнэ.
- 2.1.3 Сургалтын орчны аюулгүй байдлыг сайжруулна.
- 2.1.4 Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээг хөгжүүлнэ.
- 2.1.5 Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн баталгааг хангана.
- 2.1.6 Мэргэжлийн сургуулиудын хөгжлийг дэмжиж, хамтран ажиллана.

2.2. ЭРҮҮЛ МЭНД

- 2.2.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.
- 2.2.2 Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.
- 2.2.3 Оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ.
- 2.2.4 Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 2.2.5 Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.3. БИЕИЙН ТАМИР, СПОРТ

- 2.3.1 Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлнэ.
- 2.3.2 Үндэсний болон мэргэжлийн спортыг хөгжүүлнэ.

2.4. ГЭР БҮЛ

- 2.4.1 Гэр бүлд чиглэсэн арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулна.
- 2.4.2 Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.4.3 Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйлчилгээний чанарыг сайжруулна.
- 2.4.4 Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанарыг сайжруулна.
- 2.4.5 Хөдөлмөр эрхлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах түвшинг нэмэгдүүлнэ.
- 2.4.6 Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудыг дэмжинэ.
- 2.4.7 Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.
- 2.4.8 Гэр бүлийн гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлнэ.
- 2.4.9 Халамж зайлшгүй хүрэх шаардлагатай зорилтот бүлгүүдэд халамжийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ.

ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА

Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангах тогтолцоог бий болгож, дундаж давхаргын хүрээг тэлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ

3.1. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

3.1.1 Ажил эрхэлдэггүй, мэргэжлийн сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна.

3.1.2 Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ.

3.1.3 Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ.

3.1.4 Боловсон хүчнийг ажлын байрны захиалгад нийцүүлэн сургаж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

3.1.5 Хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хөдөлмөр эрхлэлтийн хувийг нэмэгдүүлнэ.

3.1.6 Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг цахимжуулж ашиглалтыг нэмэгдүүлнэ.

3.1.7 Аймгийн хэмжээнд хувийн хэвшилд ажиллагсдын тоог нэмэгдүүлнэ.

3.1.8 Ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувийг бууруулна.

3.2. БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТ

3.2.1 Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж, дэмжлэг үзүүлнэ.

3.2.2 Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.3 Сумдын гарааны бизнес эхлүүлж буй иргэдийн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, сум хөгжүүлэх сан, хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих сангийн зээлийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ.

3.2.4 Малчид, тариаланчид, сумын төвийн өрхүүдийн хамтын сан, хоршооны үйл ажиллагааг дэмжиж өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.

3.3. ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ

3.3.1 Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагын тоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулна.

3.3.2 Иргэдэд үйлчлэх нийтийн спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.3.3 Эрүүл зөв хооллох дадал, хэвшлийг бүх нийтэд түгээн дэлгэрүүлнэ.

3.3.4 Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдаж буй иргэдийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

3.3.5 Зорилтот бүлгүүдэд чиглэсэн амралт сувиллын газруудын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

3.3.6 Бие бялдрын сорилыг чанартай зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

3.4. ХҮНД ЭЭЛТЭЙ ОРЧИН

3.4.1 Өрхийн худалдан авах чадварт нийцсэн хямд өртөг бүхий сууцаар хангана.

3.4.2 Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

3.4.3 Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувийг нэмэгдүүлнэ.

3.4.4 Аймаг, сумын төвийн өрхүүдээс төвийн нэгдсэн халаалтад холбогдсон өрхийн тоог нэмэгдүүлнэ.

3.4.5 “Шинэ сум” төслийг хэрэгжүүлж, сумын төвүүдийн инженерийн шугам сүлжээг нэмэгдүүлнэ.

3.4.6 Төв суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайг нэмэгдүүлж, соёл амралтын хүрээлэн байгуулна.

3.4.7 Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.

3.4.8 Үерийн эрсдэлээс хамгаалагдсан өрхийн тоог нэмэгдүүлнэ.

3.5. ГАЗРЫН ХАРИЛЦАА

3.5.1 Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ.

3.5.2 Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлнэ.

3.5.3 Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг боловсруулна.

3.5.4 Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг үе шаттайгаар боловсруулна.

3.5.5 Сумдад хаягжилтын нэгдсэн системийг нэвтрүүлнэ.

ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ

Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхаргыг нэмэгдүүлж, ядуурлыг бууруулна.

4.1. БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР

- 4.1.1 Макро эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 4.1.2 Орон нутгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна.
- 4.1.3 Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлнэ.
- 4.1.4 Төсвийн үр ашигтай, ил тод, шуурхай байдлыг хангуулна.
- 4.1.5 Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэрэглээ, экспортыг нэмэгдүүлнэ.
- 4.1.6 Орон нутаг дахь үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ.
- 4.1.7 Малын гаралтай бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 4.1.8 Орон нутгийн барилгын материалын нөөцөд тулгуурласан хөнгөн үйлдвэрүүдийг байгуулж, борлуулалтын сүлжээг бий болгоно.

4.2. БИЗНЕС ЭРХЛЭХ ТААТАЙ ОРЧИН

- 4.2.1 Аймгийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 4.2.2 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг нийлүүлэх тээвэр, логистикийн төвүүдийг томоохон хотуудад байгуулна.
- 4.2.3 Орон нутгийн давуу талыг түшиглэн зэргэлдээ улс, аймгуудад бүтээгдэхүүн нийлүүлэх сувгийг өргөжүүлнэ.
- 4.2.4 Гамшгийн үеийн эдийн засгийг тогтворжуулж, хувийн салбарын санхүүгийн чадамжийг дээшлүүлнэ.

4.3. БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН

- 4.3.1 Технологи, мэдээллийн паркад суурилсан ХАА, барилгын салбар, биотехнологийн туршилтын лаборатори байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 4.3.2 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн түвшинд хөгжүүлнэ.

4.3.3 Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.

4.3.4 Дахивар бүтээгдэхүүн худалдан авах цэгүүд, боловсруулах цех байгуулна.

ТАВ. ЗАСАГЛАЛ

Цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд шилжиж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа өргөжин, хүний эрхийг хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигаас ангид аймаг байна.

5.1. УХААЛАГ ЗАСАГЛАЛ

5.1.1 Ухаалаг системд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ.

5.1.2 Төрийн албан хаагчдыг цахим хэрэглэгдэхүүн ашиглан чадавхжуулна.

5.1.3 Төрийн үйлчилгээний чанарын стандартыг бий болгож, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлнэ.

5.2. УХААЛАГ БҮТЭЦ

5.2.1 Иргэдээ сонсдог, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг тогтолцоог бэхжүүлнэ.

5.2.2 Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

5.3. ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА

5.3.1 Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.

5.3.2 Төрийн албан хаагчийн хүний нөөцийг бэлтгэж, чадавхжуулна.

5.3.3 Авлигаас ангид аймаг байна.

ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ

Байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалан, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлж хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

6.1. ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ

6.1.1 Онцлог экосистем бүхий газар нутгийг тусгай хамгаалалтанд авна.

6.2. БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ

6.2.1 Амьтны нөөцийг хамгаална.

6.2.2 Нэн ховор, ховор ургамлын генетикийн нөөцийг хамгаалж, ашиглалтын нөөц бий болгоно.

6.2.3 Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.

6.2.4 Ойн сангийн төлөв байдлыг сайжруулна.

6.2.5 Усны нөөцийн бохирдол, хомсдолоос сэргийлнэ.

6.2.6 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн механизмыг хэрэгжүүлж нөөцийн зохистой ашиглалт, хамгааллыг сайжруулна.

6.3. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН

6.3.1 Эвдэрсэн, доройтсон газрыг нөхөн сэргээнэ.

6.3.2 Байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх замаар орчны бохирдлыг бууруулна.

6.3.3 Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлнэ.

6.4. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ

6.4.1 Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ.

6.4.2 Байгаль орчны салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ БАЙДАЛ

Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлж, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулна.

7.1. БАТЛАН ХАМГААЛАХ

7.1.1 Өсвөр үе, залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгоно.

7.1.2 Орон нутгийн хамгаалалтын бэлэн байдлыг бэхжүүлнэ.

7.1.3 Дайчилгааны төлөвлөлтийг зохион байгуулна.

7.2. НИЙГМИЙН АМАР ТАЙВАН БАЙДАЛ

7.2.1 Гэмт хэргийн гаралтыг бууруулна.

7.2.2 Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.

7.2.3 Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ.

7.2.4 Орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлнэ.

7.3. ХУУЛЬ САХИУЛАХ

7.3.1 Орон нутгийн хууль сахиулах байгууллагын чадавхыг бэхжүүлнэ.

7.3.2 Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлнэ.

7.4. МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИ

7.4.1. Алслагдсан бүс нутагт үүрэн холбооны дахин дамжуулах станц байгуулж, интернетийн сүлжээг өргөжүүлнэ.

7.4.2 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлыг сурталчлан ард иргэдэд түгээнэ.

НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Үндэсний соёлоо дээдэлсэн, хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлнэ.

8.1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

8.1.1 Аймгийн аялал жуулчлалын гол, туслах маршрутад түшиглэн үйлчилгээ, мэдээллийн төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.

8.1.2 “Улаагчны хар нуур”, “Отгонтэнгэр хайрхан”-ыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

8.1.3 Аялал жуулчлалыг хөгжүүлэх иж бүрэн маркетингийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.2. ХӨДӨӨ АЖ АХУЙ

8.2.1 Эрүүл өндөр ашиг шимт мал сүргийг үржүүлнэ.

8.2.2 Бэлчээрийн даацыг нэмэгдүүлж, малын тэжээл тариалалтыг дэмжинэ.

8.2.3 Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний борлуулалтын сүлжээг бий болгоно.

8.2.4 Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ.

8.2.5 Хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг аймгийн үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангахад дэмжлэг үзүүлнэ.

8.2.6 Төв суурин газрын хүн амыг түшиглэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ.

8.2.7 Тариаланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэн, залуу тариаланч бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

8.3. ДЭД БҮТЭЦ

8.3.1 Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлнэ.

8.3.2 Улиастай болон зарим сумын инженерийн шугам сүлжээг шинэчилнэ.

8.3.3 Төв суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.

8.3.4 Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр барих барилга, байгууламж, их засварын ажлыг эрэмбэлж үе шаттайгаар шийдвэрлэнэ.

--- oOo---

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны
2020 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 12 дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт



"ЗАВХАН АЙМГИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ийн ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

№	Зорилт, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	хүрэх түвшин (2025 он)	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
НЭГ. ҮНДСЭНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ								
1,1	ӨВ СОЁЛ							
1.1.1	Соёлын биет болон биет бус өвийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сан бий болгож, өвлөн уламжлагчдыг өсвөр, үе залуучуудад сурталчлан таниулж, өвлөн уламжлуулна	Хамрагдсан хүүхэд, залуучуудын тоо	тоо	1 500	20 000	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	БСУГ, Соёлын байгууллага
1.1.2	Номын сангийн цахим сан хөмрөгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ	Цахим сан хөмрөгийн эзлэх хувь	хувь	0%	4,0%	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	БСУГ, Төв номын сан
1.1.3	Үндэсний бахархал, Монгол өв соёлоо өвлүүлэхэд чиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно	Бүтээгдэхүүний тоо	тоо	3	24	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	БСУГ, БОАЖГ
1.1.4	Монгол хэл, бичгийн хэрэглээг нийтийн болон албан хэргийн түвшинд нэмэгдүүлнэ	Монгол хэл бичгийг хэрэглэж буй хувь	хувь	30%	40%	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	ХБҮЗ-ийн Завхан аймаг дахь салбар зөвлөл, БСУГ
1.1.5	"Үндэсний бахархал, Монгол өв соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ	Гүйцэтгэлийн хувь	хувь	30%	80%	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	СЯ, БСУГ, Соёл урлагийн байгууллага
1.1.6	Соёлын биет, биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна	Хэрэгжилтийн хувь	хувь	20%	75%	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	СЯ, БСУГ, Соёл урлагийн байгууллага
1.1.7	Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмж, нэр төрөл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ	Үйлчилгээний хүртээмж	хувь	35%	60%	2020 оны суурь түвшин	Жилд 2 удаа	СЯ, БСУГ, Соёл урлагийн төрийн болон төрийн бус байгууллага
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ								
2,1	БОЛОВСРОЛ							
2.1.1	Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ	Хамрагдалтын хувь	хувь	30%	95%	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	БСУГ, сургалтын байгууллага
2.1.2	Бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлнэ	Чанарын үнэлгээ	хувь	38%	45%	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	БСУГ, бүх шатны сургалтын байгууллага
2.1.3	Сургалтын орчны аюулгүй байдлыг сайжруулна	Сургалтын байгууллагын эзлэх хувь	хувь	60%	80%	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	БСУГ, сургалтын байгууллага
2.1.4	Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээг хөгжүүлнэ	Хамрагдалтын хувь	хувь	60%	85%	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	БСУГ, сургалтын байгууллага
2.1.5	Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлнэ	Хэрэгжилтийн хувь	хувь	30%	80%	2020 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	БСУГ, Төсөл хөтөлбөр

2.1.6	Мэргэжлийн сургуулиудын хөгжлийг дэмжин, хамтран ажиллана	Хэрэгжилтийн хувь	хувь	10%	50%	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	МБСБ
2.2	ЭРҮҮЛ МЭНД							
2.3.1	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ	Нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багцын хэрэгжилтийн хувь	хувь	70%	80%	2019 оны суурь түвшин	Улиралд нэг удаа	ЭМГ
2.2.2	Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	Хамрагдалтын хувь	хувь	70%	90%	2019 оны суурь түвшин	Жилд хоёр удаа	ЭМГ
2.2.3	Оношлогоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлнэ	Нэвтрүүлсэн технологи	тоо	2	5	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЭМГ
2.2.4	Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ	Хамрагдалтын хувь	хувь	70%	100%	2019 оны суурь түвшин	Хагас жилд нэг удаа	НЭ, ЭМГ
2.3	БИЕЙН ТАМИР, СПОРТ							
2.3.1	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлнэ	Үйлчилгээний хүртээмж	хувь	22%	40%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	БТСГ, БСУГ
2.3.2	Үндэсний болон мэргэжлийн спортыг хөгжүүлнэ	Тамирчидын тоо	тоо	1830	4500	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	БТСГ, БСУГ
2.4	ГЭР БҮЛ							
2.4.1	Гэр бүлд чиглэсэн арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулна	Хамрагдсан тоо	тоо	4,993	6,000	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГБХЗХГ
2.4.2	Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ	Нийт төсвийн зарцуулсан хөрөнгийн хувь	хувь	0%	10%	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ
2.4.3	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах үйлчилгээний чанарыг сайжруулна	Хүний тоо	тоо	21	96	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГБХЗХГ
2.4.4	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанарыг сайжруулна	Үйлчилгээний чанарын хувь	хувь	25%	99%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГБХЗХГ
2.4.5	Хөдөлмөр эрхлэлтэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах түвшинг нэмэгдүүлнэ	Хүний тоо	тоо	109	172	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХҮГ
2.4.6	Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудыг дэмжинэ	Зөвлөхийн тоо	тоо	202	300	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХҮГ
2.4.7	Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ	Залуучуудын тоо	тоо	109	172	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХҮГ

2.4.8	Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлнэ	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	202	300	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХҮГ
2.4.9	Халамж зайлшгүй хүрэх зорилтот бүлгүүдэд халамжийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ	Үйлчилгээ авсан иргэдийн тоо	тоо	16176	15124	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХҮГ
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА								
3.1.	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ							
3.1.1	Ажил эрхэлдэггүй, мэргэжлийн сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна	Залуучуудын эзлэх хувь	хувь	25.7%	15%	2018 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, ХХҮГ
3.1.2	Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ	Ажиллах хүчний оролцооны түвшин	хувь	80%	88%	2019 оны суурь түвшин	Улирал бүр	АЗДТГ, ХХҮГ
3.1.3	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ	Шимтгэл төлсөн иргэдийн хувь	хувь	23%	60%	2019 оны суурь түвшин	Улирал бүр	АЗДТГ, ХХҮГ
3.1.4	Боловсон хүчнийг ажлын байрны захиалгад нийцүүлэн сургаж ажилгүйдлийн түвшинг бууруулна	Ажилгүйдлийн түвшин	хувь	6.2%	5.9%	2019 оны суурь түвшин	Улирал бүр	ХХҮГ
3.1.5	Хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хөдөлмөр эрхлэлтийн хувийг нэмэгдүүлнэ	Хөдөлмөрийн насны хүн амын ажил эрхлэлтийн түвшин	хувь	74.4%	93.0%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, ХХҮГ
3.1.6	Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг цахимжуулж ашиглалтыг нэмэгдүүлнэ	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийг бүртгэлжүүлж, ажилд зуучилсан тоо	тоо	350	1,500	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХҮГ
3.1.7	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	Ажлын байрны тоо	тоо	1250	4500	2020 оны суурь түвшин	Улирал бүр	АЗДТГ, ХХҮГ
3.1.8	Ядуурлын үндэсний түвшнээс доогуур амьжиргаатай хүн амын эзлэх хувийг багасгана	Ядуурлын түвшингээс доогуур орлоготой хүн амын хувь	хувь	25.7%	18%	2018 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, ХХҮГ
3.2.	БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТ							
3.2.1	Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлж дэмжлэг үзүүлнэ	Санхүүгийн сургалтад хамрагдаж ЖДҮ, ХЭДС-ийн зээл авсан өрхийн хувь	хувь	10%	100%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Монголбанкны Завхан салбар, Төслийн байгууллагууд
3.2.2	Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерын зарчмаар хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ	Нийлүүлэлтийн гинжин харилцаа тогтоосон бизнес, үйлдвэрийн тоо	тоо	0	5	2020 оны суурь түвшин	Жилд 1 удаа	ХХААГ, ХАУТанхим, Төсөл хөтөлбөрүүд
3.2.3	Сумдын гарааны бизнес эхлүүлж буй иргэдийн ЖДҮХС, СХС, ХЭДС-ийн зээлийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ	Анх удаа тухайн сангаас зээл авсан зээлдэгч	хувь	10%	30%	2020 оны суурь түвшин	Улирал бүр	ХХҮГ
3.2.4	Малчид, тариаланчид, сумын төвийн өрхийн хамтын сан, хоршооны үйл ажиллагааг дэмжиж өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ	Зохион байгуулалтад орж дундын хуримтлалын сантай болсон бүлэг, хоршоо	тоо	1350	2500	2020 оны суурь түвшин	Улирал бүр	ХХҮГ, Сумын ЗДТГ, ХХААГ
3.3.	ЭРҮҮЛ, ИДЭВХТЭЙ АМЬДРАЛ							

3.3.1	Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагын тоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулна	Шинээр ашиглалтанд орсон спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагын тоо	тоо	43	70	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЭМГ, БТСГ
3.3.2	Иргэдэд үйлчлэх нийтийн спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ	Шинээр байгуулагдсан спортын гадна талбай, тоглоомын талбайгаар хэмжинэ	тоо	23	50	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЭМГ, БТСГ
3.3.3	Эрүүл зөв хооллох дадал, хэвшлийг бүх нийтэд түгээн дэлгэрүүлнэ	Чиглэлийн байгууллагаар үйлчлүүлсэн иргэдийн тоогоор хэмжинэ	тоо	520	1250	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЭМГ, БТСГ
3.3.4	Нийгмийн хамгааллын суурь хөтөлбөрт хамрагдаж буй иргэдийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна	Хамрагдсан иргэд	хувь	58%	82%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЭМГ, БТСГ
3.3.5	Зорилтот бүлгүүдэд чиглэсэн амралт, сувиллын газруудын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ	Хамрагдсан иргэдийн тоо	тоо	500	2000	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЭМГ, БТСГ
3.3.6	Бие бялдрын сорилыг чанартай зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ	Сорилд хамрагдалтын хувь	хувь	17.6%	73.5%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ЭМГ, БТСГ
3.4.	ХҮНД ЭЭЛТЭЙ ОРЧИН							
3.4.1	Өрхийн худалдан авах чадварт нийцсэн хямд өртөг бүхий орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлнэ	Орон сууцаар хангагдсан өрхийн тоо	тоо	50	100	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.4.2	Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ	Хүн амын эзлэх хувь	хувь	70%	85%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.4.3	Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн нийт өрхөд эзлэх хувийг нэмэгдүүлнэ	Өрхийн эзлэх хувь	хувь	24%	30%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.4.4	Аймаг, сумын төвийн өрхүүдээс нэгдсэн халаалтанд холбогдсон өрхийн тоог нэмэгдүүлнэ	Халаалтанд холбогдсон өрхийн эзлэх хувь	тоо	12%	20%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.4.5	"Шинэ сум" төслийг хэрэгжүүлж, сумын төвүүдийг стандартад нийцсэн ус, ариун цэврийн байгууламжтай болгоно	Байгууламжийн тоо	тоо	3	6	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.4.6	Сум, суурин газруудын ногоон байгууламжийн эзлэх талбайг нэмэгдүүлж, соёл амралтын хүрээлэн байгуулна	Ногоон байгууламжийн талбай	га	12.6	38.0	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.4.7	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	Үйлчилгээгээр хангагдсан иргэдийн хувь	хувь	2%	25%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.4.8	Үерийн эрсдэлээс хамгаалагдсан өрхийн тоог нэмэгдүүлнэ	Байгууламжийн тоо	тоо	0	3	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ

3.5. ГАЗРЫН ХАРИЛЦАА								
3.5.1	Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулна.	Төлөвлөгөө боловсруулагдсан сумын тоо	тоо	3	6	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.5.2	Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлнэ	Зах зээлийн үнийн мэдээ болон газрын дуудлага худалдааны тоо	тоо	823	5851	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.5.3	Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг боловсруулна	Төлөвлөлтөнд орон зайн төлөвлөлт ашигласан сум, байгууллагын тоо	тоо	17	41	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.5.4	Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг үе шаттай боловсруулна	Сумын тоо	тоо	3	6	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
3.5.5	Сумдад хаягжилтын нэгдсэн системийг нэвтрүүлнэ	Стандартын хаягжилт хийгдсэн өрхийн тоо	тоо	14	24	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ, СЗДТГ
4.1. ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ								
БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭР								
4.1.1	Макро эдийн засгийг хөгжлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	Хувиар	хувь	7%	3%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, агенталгууд
4.1.2	Орон нутгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулна	Эдийн засгийн салбаруудын бүтэц ДНБ-д эзлэх хувиар хэмжинэ	хувь	32.5%	48.0%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, агенталгууд
4.1.3	Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлнэ	Төсвийн орлого	сая төгрөг	7,670	9,858	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, ТХ
4.1.4	Төсвийн үр ашигтай, ил тод, шуурхай байдлыг хангуулна	Төсвийн зардал	сая төгрөг	22,152	22,747	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Төсвийн байгууллага
4.1.5	Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэрэглээ, экспортыг нэмэгдүүлнэ	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	сая.төг	3,094.50	5,453.57	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХААГ
4.1.6	Орон нутаг дахь үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний борлуулалтаар хэмжинэ	сая.төг	4,373.60	7,043.73	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХААГ
4.1.7	Малын гаралтай бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ	Малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтын орлого	сая.төг	23,247	37,716	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХААГ
4.1.8	Орон нутгийн барилгын материалын нөөцөд тулгуурласан хөнгөн үйлдвэрүүдийг байгуулж, борлуулалтын сүлжээг бий болгоно	Орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээр хэмжинэ	сая.төг	2,436	4,899	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ГХБХБГ

БИЗНЕС ЭРХЛЭХ ТААТАЙ ОРЧИН								
4.2.1	Аймгийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ	сая.төг	25,980	39,281	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, ХХААГ
4.2.2	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг нийлүүлэх тээвэр, логистикийн төвүүдийг томоохон хотуудад байгуулна	Байгуулагдсан агуулах худалдааны төвөөр дамжуулан борлуулсан бүтээгдэхүүний хэмжээ	борлуулалт /сая.төг/	0	400.0	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХААГ, ХАҮТ
4.2.3	Орон нутгийн давуу талыг түшиглэн зэргэлдээ улс, аймгуудад бүтээгдэхүүн нийлүүлэх сувгийг өргөжүүлнэ	Хөрш зэргэлдээ улс, аймгуудтай хийсэн худалдааны хэлэлцээр, гэрээ, бий болсон сувгийн тоо	тоо	0	15	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХААГ
4.2.4	Гамшгийн үеийн эдийн засгийг тогтворжуулж, хувийг салбарын санхүүгийн чадамжийг дээшлүүлнэ	Санхүүжилтийн хэмжээ	сая.төг	50	500	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, Аймаг, сумдын онцгой комисс
БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН								
4.3.1	Технологи, мэдээллийн паркар суурилсан ХАА, барилгын салбар, биотехнологийн туршилтийн лаборатори байгуулахад дэмжлэг үзүүлнэ	Туршилтаар хийгдсэн бүтээгдэхүүний тоо	тоо	0	25	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХААГ
4.3.2	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн түвшинд хөгжүүлнэ	Завхан аймгийн брэнд бүтээгдэхүүний хөгжүүлэлт, технологижуулалтанд зарцуулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	сая.төг	400	1,200	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХХААГ, СЗДТГ
4.3.3	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ	Худалдан авалтанд эзлэх хувь	хувь	12%	50%	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	ХААГ, СЗДТГ
4.3.4	Дахивар бүтээгдэхүүн худалдан авах цэгүүд, боловсруулах цех байгуулна	Боловсруулсан бүтээгдэхүүний хэмжээ	тонн	0	50	2020 оны суурь түвшин	Хагас жилд нэг удаа	БОАЖГазар, СЗДТГазар
			ТАВ. ЗАСАГЛАЛ					
УХААЛАГ ЗАСАГЛАЛ								
5.1.1	Ухаалаг системд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ	Төрийн үйлчилгээг цахимаар авсан иргэдийн хувь	хувь	15%	60%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ, СЗДТГ
5.1.2	Төрийн албан хаагчдыг цахим хэрэглэгдэхүүн ашиглан чадавжуулна	Төрийн байгууллагын тоо	тоо	5	42	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Төрийн байгууллагууд
5.1.3	Төрийн үйлчилгээний чанарын стандартыг бий болгож, төрийн үйлчилгээнд иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдэн, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёл төлөвшүүлнэ	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн хувь	хувь	60.5%	61.5%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	АЗДТГ

5.2	УХААЛАГ БҮТЭЦ							
5.2.1	Иргэдээ сонсдог, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг тогтолцоог бий болгоно	Оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ	сая.төг	80.0	105.0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймаг, сумын ЗДТГ
5.2.2	Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ	Хамтран ажиллахаар байгуулсан гэрээний тоо	тоо	10	65	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймаг, сумын ЗДТГ
5.3	ЧАДВАРЛАГ ТӨРИЙН АЛБА							
5.3.1	Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ	Нийгмийн асуудлыг хангахад зарцуулсан хөрөнгө оруулалтын дүн	сая.төг	15.0	40.0	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймаг, сумдын ЗДТГ
5.3.2	Төрийн албан хаагчийн хүний нөөцийг бэлтгэж, чадавжуулна	Сургалтанд хамрагдсан ТАХ-ийн тоо	тоо	5,299	10,500	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймаг, сумдын ЗДТГ
5.3.3	Авлигаас ангид аймаг байна	Авлигын индекс	индекс	81.1%	92.0%	2019 оны суурь түвшин	Жилд нэг удаа	Аймаг, сумдын ЗДТГ
ЗУРГАА: НОГООН ХӨГЖИЛ								
6.1	ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ							
6.1.1	Онцлог экосистем бүхий газар нутгийг тусгай хамгаалалтанд авна	Нийт тусгай хамгаалалттай газар нутаг	хувь	42.5%	46.5%	2020 оны суурь түвшин	5 жилд нэг удаа	БОАЖГ, ГХБХБГ, төсөл хөтөлбөр
6.2	БАЙГАЛИЙН НӨӨЦ БАЯЛАГ							
6.2.1	Амьтны нөөцийг хамгаална	Хэрэгжүүлсэн хамгааллын арга хэмжээ	тоо	7	16	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	БОАЖГ, ТХГНХЗ, СЗД
6.2.2	Нэн ховор, ховор ургамлын генетикийн нөөцийг хамгаалж, ашиглалтын нөөц бий болгоно	Хамгаалагдсан зүйл	тоо	26	26	2020 оны суурь түвшин	Жилд нэг удаа	БОАЖГ, ТХГНХЗ, СЗД
6.2.3	Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ	Ойгоор бүрхэгдсэн талбай	хувь	6%	6.10%	2018 он суурь түвшин	Жилд нэг удаа	БОАЖГ, СДОА, СЗДТГ, ААН
6.2.4	Ойн сангийн төлөв байдлыг сайжруулна	Шатсан ойн талбайн хэмжээ	мян.га	133	124	2017 оны суурь түвшин	Жилд нэг удаа	БОАЖГ, СДОА, СЗДТГ, ААН
